



**Монголын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагын
үйл ажиллагааны тайлан**

2015 он

**Монголын ОУИТБС-ын Үндэсний зөвлөл, Ажлын хэсэг
Ажлын алба**

АГУУЛГА

Нэг. 2015 оны хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, үр дүнгийн тухай;

Хоёр. ОУИТБС-ын шаардлага бүрийг хангасан байдал, явц;

Гурав. Баталгаажуулалтын зөвлөмжийн дагуу Үндэсний зөвлөл, Ажлын хэсгээс хэрэгжүүлсэн арга хэмжээний тойм;

Дөрөв. Ажлын төлөвлөгөөний биелэлтийн байдал, биелсэн зорилтуудын ач холбогдол;

Тав. Цаашид хэрэгжүүлэх ажлын томъёолол, оролцогч талуудын оролцоог нэмэгдүүлэх тухай;

Зургаа. Монгол Улсад 2015 онд ОУИТБС-ыг хэрэгжүүлэхэд үүсэн бэрхшээл, хариу арга хэмжээ, авсан сургамж

Долоо. Тайланг боловсруулсан, баталсан огноо;

НЭГ. 2015 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА, ҮР ДҮНГИЙН ТУХАЙ

1.1. Үндэсний зөвлөл, Ажлын хэсгийн хуралдаануудын тойм

Үндэсний зөвлөл

Монгол Улсын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хянан зохицуулах үүрэг бүхий Үндэсний зөвлөл 2015 оны 1, 6, 12 дугаар сард, нийт 3 удаа хуралдсан байна. 2015 оны 1 дүгээр сарын хурал нь 2014 онд хамааралтай хурал бөгөөд Монгол Улсын Засгийн газар шинэчлэгдэж, шийдлийн Засгийн газар байгуулагдсантай холбоотойгоор хурлыг ондоо зохион байгуулж чадаагүй болно. Хуралдаан бүрийн шийдвэрийг сийрүүлэв. Үүнд:

2015 оны 1 дүгээр сарын 13-ны өдөр¹

1. Монгол Улсын ОУИТБС-ын 2013 оны буюу наймдугаар тайланг хэлэлцэж батлав.
2. Монголын ОУИТБС-ын 2014 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлттэй танилцаж, хангалттай гэж үзэв.
3. Монголын ОУИТБС-ын 2015 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний төсөлтэй танилцан нэмэж, санала оруулан батлав.

2015 оны 6 дугаар сарын 4-ний өдөр²

Хуралдаанд ОУИТБС-ын Олон улсын удирдах хорооны дарга хатагтай К.Шорт оролцож, Монгол Улсад ОУИТБС-ыг амжилттай хэрэгжүүлж байгаад сэтгэл хангалуун байгаа илэрхийлэхийн хамт 3 тал идэвхтэй хамтран ажиллахыг хүссэн байна.

Мөн Монгол Улсын Их хурлын эдийн засгийн байнгын хорооны дарга Ж.Батсуурь хуралдаанд оролцож, эрхэм зочинд хүндэтгэл үзүүлэхийн хамт, эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулийн төслийг дэмжиж байгаагаа илэрхийлсэн байна.

Үндэсний зөвлөлийн 2015 оны 1 дүгээр сарын хуралдааны дагуу байгуулагдсан 5 дэд хэсгийн а/Эрдэс баялгийн салбар дахь гэрээний ил тод байдлыг хангах, б/ОУИТБС-ын тайланг аудитаар баталгаажуулах, в/Уул уурхайн салбарын аж ахуйн нэгжүүдэд хууль жигд, ялгаваргүй үйлчлэх, АМНАТ, жишиг үнийн асуудлыг ойлгомжтой болгох тухай судалгаа хийх, зөвлөмж боловсруулах ажлын эхний үр дүнтэй танилцаж, зарчимын хувьд үр дүнг дэмжиж, ажлуудыг дуусгахыг холбогдох хэсгүүдэд даалгасан байна.

2015 оны 12 дугаар сарын 18-ны өдөр³

1. Монгол Улсын ОУИТБС-ын 2014 оны буюу есдүгээр тайланг хэлэлцэж, батлав. Цаашид авах арга хэмжээнүүдийн холбогдох шийдвэрүүдийг гаргав.
2. Монголын ОУИТБС-ын 2015 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг хангалттай гэж үзэв.
3. Монголын ОУИТБС-ын 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг зарчимын хувьд батлав. Гишүүдээс гарсан саналыг баталсан байна.
4. Монголын ОУИТБС-ын Үндэсний зөвлөлийн зөвлөлийн журамд оруулах нэмэлт өөрчлөлтийг батлав.
5. ОУИТБС-ын орон нутгийн дэд зөвлөлийн тогтвортой, үр дүнтэй үйл ажиллагааг хангахад тулгарч буй бэрхшээлийг шийдвэрлэж 2016 оныг дэд зөвлөлийг чадавхжуулах жил болгохоор тогтлоо.

Ажлын хэсэг

¹ Дэлгэрэнгүйг хурлын тэмдэглэлийг Ажлын албаны цахим хуудаснаас үзнэ үү.

² Дэлгэрэнгүйг хурлын тэмдэглэлийг Ажлын албаны цахим хуудаснаас үзнэ үү.

³ Дэлгэрэнгүйг хурлын тэмдэглэлийг Ажлын албаны цахим хуудаснаас үзнэ үү.

ОУИТБС-ыг хэрэгжүүлэх үүрэг бүхий олон талт Ажлын хэсэг 2015 оны 5, 10, 12 дугаар саруудад тус бүр 1 удаа, бүгд 3 удаа хуралдав. Хуралдаан бүрийн шийдвэрийг сийрүүлэв. Үүнд:

2015 оны 5 дугаар сарын 25-ны өдөр⁴

Хэлэлцсэн асуудал ба шийдвэрүүдийг сийрүүлэв.Үүнд:

1. Монгол Улсын ОУИТБС-ын цахим тайлагналын журмыг батлав.
2. ОУИТБС-ын Ажлын хэсэг, Үндэсний зөвлөлийн журамд нэмэлт оруулах тухай саналыг хүлээн авч, холбогдох нэмэлтийг оруулахаар тогтов.
3. ОУИТБС-ын тэргүүн хатагтай К.Шортын айлчлалын бэлтгэлийн тухай сонсож, танилцав.
4. Монгол Улсын ОУИТБС-ын 2013 оны тайлангийн мөрөөр хэрэгжүүлэх ажлыг боловсруулах ажлын 5 дэд хэсгийн тайлангийн урьдчилсан дүнг сонсч, Үндэсний зөвлөлд танилцуулахаар тогтов.

2015 оны 10 дугаар сарын 8-ны өдөр⁵

Хэлэлцсэн асуудал ба шийдвэрүүдийг сийрүүлэв.Үүнд:

1. Монгол Улсын ОУИТБС-ын аймаг, нийслэл, сум, дүүргийн дэд зөвлөлийн үйл ажиллагаа, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар хэлэлцэж, Дэд зөвлөлийн үйл ажиллагааны санхүүгийн боломжийг судлах дэд ажлын хэсэг байгуулж ажиллуулах тухай шийдвэрийг гаргав.
2. ОУИТБС-ын тайлангийн маягтад оруулах нэмэлт өөрчлөлтийг баталж, Үндэсний Статистикийн хороонд танилцуулж, шийдвэрлүүлэхээр тогтов.
3. Монгол Улсын ОУИТБС-ын 2014 оны тайлангийн явцыг сонсч, түргэтгэх ажлыг зохион байгуулахаар шийдсэн байна.
4. ОУИТБС-ын 7 дугаар бага хуралд оролцохоор болж, төлөөлөгчидийн нэрсийг холбогдох байгууллагуудаас ирүүлэхийг хүсэлт болгов.

2015 оны 12 дугаар сарын 11-ний өдөр⁶

Хэлэлцсэн асуудал ба шийдвэрүүдийг сийрүүлэв.Үүнд:

1. Монгол Улсын ОУИТБС-ын 2014 оны тайлангийн төслийг дэмжиж, Үндэсний зөвлөлд танилцуулж, батлуулах болон бусад шаардлагатай гэсэн шийдвэрүүдийг гаргав.
2. Монгол Улсын ОУИТБС-ын 2015 оны үйл ажиллагааны урьдчилсан тайланг сонсч, тайлбар авсны үндсэн дээр Үндэсний зөвлөлд танилцуулахаар тогтов.
3. Монгол Улсын ОУИТБС-ын 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийн сонсч, саналаа гарган, нэгтгэж Үндэсний зөвлөлд танилцуулахаар тогтов.

1.2.Монголын ОУИТБС-ын 2014 оны нэгтгэл тайлангийн тойм

Монгол Улсын ОУИТБС-ын 2014 оны нэгтгэлийг хийж гүйцэтгэхээр Монгол, Франц улсуудын Кей Пи Эм Жи Компаниудын концерцум шалгарч, гэрээт ажлаа 2014 оны 7 дугаар сарын эхээр эхлүүлсэн.

⁴ Дэлгэрэнгүйг хурлын тэмдэглэлийг Ажлын албаны цахим хуудаснаас үзнэ үү.

⁵ Дэлгэрэнгүйг хурлын тэмдэглэлийг Ажлын албаны цахим хуудаснаас үзнэ үү.

⁶ Дэлгэрэнгүйг хурлын тэмдэглэлийг Ажлын албаны цахим хуудаснаас үзнэ үү.

Энэ нэгтгэлд 236 компанийн төлбөр, тэднээс Засгийн газрын хүлээн авсан орлогын аудитын нэгтгэлийг явуулж, 7 дугаар сарын эхлэлийн семинарыг зохион байгуулж, 8 дугаар сард эхлэлийн тайланг гаргаж, 10 дугаар сард Ажлын хэсэгт, 11 дүгээр сарын эхээр зохиогдсон ОУИТБС-ын Үндэсний чуулган, Туршилтын баталгаажуулалтын хүрээнд тайлангийн явцыг танилцуулан, 2015 оны 12 дүгээр сарын эхээр дуусгаж, төслийг Ажлын хэсгээр 12 дугаар сард танилцуулан, дэмжлэг авсны үндсэн дээр Үндэсний зөвлөл 2015 оны 12 дугаар сарын 18-ны баталсан байна.

Ерөнхий хэсэг

2014 онд олборлох салбар нь Монгол Улсын Дотоодын нийт бүтээгдэхүүний 17,1%, аж үйлдвэрийн бүтээгдэхүүний 60%, экспортын 89%-ийг бүрдүүлсэн байна.

2014 онд олборлох үйлдвэрлэлээс ЗГ-ын хүлээн авсан нийт орлого 1632 тэрбум төгрөг, үүнээс 565 тэрбум нь АМНАТ, 286 тэрбум нь газрын тосны орлого, 201 тэрбум ААНОАТ байжээ.

2014 онд Монгол Улсын нийт 1,070 мянган хөдөлмөр эрхлэгчдийн 41,3 мянга нь уул уурхайн салбарт ажиллаж байгаа нь нийт ажиллагсдын 3,7% нь болж, өнгөрсөн жилээс 20 хувиар буурсан байна. Энэхүү тайлангаар нэгтгэлд орсон компаниуд нь 80 нь ажиллагсдынхаа талаар мэдээлэл өгсөн байна. Нийт 26,9 мянган хүн ажилладаг гэж мэдүүлсний 991 нь буюу 10 хүрэхгүй хувь нь гадаадын ажиллагсад байжээ.

2015 онд ОУИТБС-ын тайлан гаргах 1573 компаниас 988 компани цахимаар тайлангаа гаргасан нь 57 хувь болж өнгөрсөн жилээс 200 орчим компани буюу 12 орчим хувиар буурсан байна. Тайлангаа гаргасан 988 компаниудын төвлөрүүлсэн нийт орлогын дүн 1650 тэрбум төгрөг бол Засгийн газрын 1573 компаниас хүлээн авсан дүн 1920 тэрбум төгрөг байсан бөгөөд материаллаг босгыг шинэчлэн тогтоосноор 236 компаниудын тайланг нэгтгэсэн нь 2014 оны гол орлогын урсгалын нийт 98,8 хувийг эзэлж байна. Нэгтгэлийн эцэст Засгийн газрын тохируулагдсан дүн 1579 тэрбум, компаниудынх 1582 тэрбум төгрөг, болсноор цэвэр, тайлбарлагдаагүй зөрүү 581 сая төгрөг гэдгийг нотолсон байна.

Зөрүүний шалтгаанд 1/Компани нь цахимаар тайлангаа ирүүлээгүй, 2/төлбөрөө хэтрүүлэн тайлагнасан, 3/төлбөрийг буруу төлбөрийн ангилалд мэдээлсэн, 4/буцаагдсан төлбөрүүдийг компанийн тайланд тохируулаагүй, 5/төлбөрүүд нь өөр компанийн нэрийн өмнөөс хийгдсэн, 6/ОУ-ээс бусад үйл ажиллагаатай холбогдсон төлбөрүүдийг тайлагнасан, тухайлбал, барилга, 7/Төлбөрүүд цэвэр дүнгээр бичигдсэн, 8/ЗГ-ын тайланд орсон компаниуд нь 2014 онд олборлох үйл ажиллагаа явуулаагүй, 9/Анхны тайлангийн маягтад мянгачилсан оронгоор тайлагнах байсныг ЗГ-ын байгууллагууд нэгж төгрөгөөр тайлагнасан байна.

Шийдвэрлэгдээгүй зөрүүнд нэмэгдсэн өртөгийн албан татвар, аж ахуйн нэгжийн орлогын татвар тэргүүлж байна.

Хандив дэмжлэг 2012 оны тайлангаар 13,1 тэрбум төгрөгөөр нотлогдсон бол 2013 онд 39,2 тэрбум төгрөг бараг 3 дахин өссөн бол харин 2014 онд 19 тэрбум төгрөг болж буурсан байна.

2014 онд Газрын тосны тухай хуулийг шинэчлэн баталж, эрх зүйн зохицуулалт тодорхой болсон байна. Газрын тосны хайгуул, олборлолт эрхлэхэд тусгай зөвшөөрөл авах, шинээр олгосон хайгуулын хугацаа 8 жил, түүнийг 2 удаа 2 жилээр сунгах зэрэг олон шинэлэг зүйл орсон байна⁷.

⁷ Дэлгэрэнгүйг 2014 оны нэгтгэлийн тайлангаас үзнэ үү.

Олборлох үйлдвэрлэлд 2014 онд 1557 компани 2736 тусгай зөвшөөрөлтэй талбай дээр 57 төрлийн ашигт малтмалын хайгуулын болон олборлолтын үйл ажиллагаа эрхэлж байна. 2736 тусгай зөвшөөрлийн талбай нь 11 сая га болж байна. Газрын тосны 17 компани буюу 22 бүтээгдэхүүн хуваах гэрээ бүхий аж ахуйн нэгж, цацраг идэвхт ашигт малтмалын хайгуулын 15 компани буюу 57 тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж, 2014 оны эцсийн дүнгээр ажиллаж байв.

2014 оны нэгтгэл тайлангаар Тусгай зөвшөөрлийн бүртгэл, олголт, Монгол улсын эдийн засагт олборлох үйлдвэрлэлээс оруулж буй хувь нэмэр, төсвийн орлого, хуваарилалт, зарцуулалт, тусгай сангуудын орлого, зарлага, дэд бүтцийн хөрөнгө оруулалт болон бараа материалын солилцоо, хандив дэмжлэг, давуу эрхтэй хувьцаа эзэмшигчдийн талаархи мэдээлэл хэвлэн нийтлүүлэх ОУИТБС-ын стандартын шаардлагууд Монгол Улсад ямар түвшинд байгааг дүгнэж, холбогдох судалгааг гаргасан байна.

Тайланд уулын ажлын төлөвлөгөөний биелэлт, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн ажлын мэдээг оруулж холбогдох дүгнэлтийг танилцуулсан байна.

Компаниудын оролцоо

Нэгтгэлд компаниудын оролцоо өмнөх жилүүдээс сайн байсан хэдий ч зарим компаниуд хариу өгөлгүй ажлыг саатуулсан байна. Тайлагнаагүй компаниудыг дурдвал Эрдэнэс Шаширт майнинг Ресурс ХХК, Юүшэнгминг, Угалзан цамхаг, Монголболгаргео, Спейшл майнз, Гангар Инвест, Ган-Ил бөгөөд Засгийн газраас хүлээн авсан орлого нь 1051 сая төгрөг байсан. Монголболгаргео, Угалзан цамхаг компаниудын хандлага давтагдсан байна.

Засгийн газрын байгууллагуудын оролцоо

Засгийн газрын байгууллагуудын оролцоо хангалттай түвшинд байжээ.

Монголын ОУИТБС-ын 2014 оны нэгтгэл тайлангийн зөвлөмжүүдийг товчлон танилцуулахад:

1. Төлбөрийн тайлагналд ашигласан мэдээлэл технологийн платформ, холбогдох мэдээлэл технологийн хяналтууд болон түүний орчныг сайжруулах чиглэлээр цахим тайлагналын 2 дугаар шатанд шалгалт явуулах;
2. Цахим тайлангийн систем ашиглан, электрон хэлбэрээр цуглуулах үндсэн мэдээллийн хэлбэр, цар хүрээг тодорхойлох, маягтын загварыг гаргахад Хараат бус хянан нэгтгэгчийг оролцуулах;
3. Компаниудад ОУИТБС-ын ач холбогдолыг бүхэлд нь илүү сайн сурталчилах;
4. Олборлох үйлдвэрлэлийн үйл ажиллагааны орлогыг бусад үйл ажиллагаанаас ялгах, ангилах;
5. Төслийн түвшиний ил тод байдлын хүрээнд ил тод болгох ажлыг эхлүүлэх;
6. Компаниудтай холбоо барих лавлагааг 2015 оны цахим тайлагналын хүрээнд шинэчлэх ;
7. Тайлагналын зааварчилгааг сайжруулах;
8. Төрийн өмчийн ААН-ийг дэмжиж, ОУИТБС-ын стандартын дагуу бүх мэдээллээ ил тод болгохыг хичээх, саад бэрхшээлийг арилгах;
9. Төрийн бүх шатны байгууллагуудаас тайлагнасан мэдээллийн баталгаажуулалтыг сайжруулах;
10. Компаниудаас тайлагнасан санхүүгийн мэдээлэл болон үндсэн мэдээлэлд хязгаарлагдмал баталгаажуулалт шаардлагатайг компаниудад тодруулж өгөх;
11. ОУИТБС-ын стандартын дагуу кадастраас шаардсан мэдээллийг гаргуулах;
12. Хараат бус хянан нэгтгэгчийг аль болгох эрт сонгон шалгаруулах, ажлыг эртлэн хийлгэх;

1.3 Монголын ОУИТБС-ын 2014 оны нэгтгэл тайлан гаргах аудитын консерциумыг сонгон шалгаруулсан нь

Монголын ОУИТБС-ын 2014 оны нэгтгэл тайлан гаргах аудитын консерциум шалгаруулах удирдамжийг 2015 оны 2 дугаар сарын сүүлчээр Засгийн газрын хэрэг эрхлэх газраас батлуулж, Үнэлгээний хороог байгуулсан байна. Үнэлгээний хорооны удирдамжийг боловсруулж, Монголын ОУИТБС-ын Ажлын хэсгийн гишүүдээс саналыг нь цахимаар авч, холбогдох нэмэлт өөрчлөлтийг ОУИТБС-ын 2013 оны шинэ стандартын шаардлагуудтай хамт оруулсан байна.

Сонгон шалгаруулалтыг 2015 оны 3 дугаар сараас эхлэн явуулж, 5 дугаар сарын эцсээр дуусгаж, Монгол, Франц улсуудын Кей Пи Эм Жи компаниудын консерциум шалгарсан боловч Их Британийн Мооре Стефенс, Монголын Далайван аудит компаниудын консерциум гомдол гаргаж, Сангийн яаманд асуудал тавьсан байна. Гомдлын агуулга нь техникийн саналын үнэлгээнд эргэлзэж байгаагаа илэрхийлж, шалгаж өгөхийг хүссэн байна. Сангийн яамнаас гомдлыг хянан хэлэлцэж, гомдол гаргах үндэслэлгүй гэсний дагуу гэрээг 6 дугаар сарын дундуур байгуулж, гэрээт ажлыг нь 7 дугаар сарын эхээр эхлүүлж, 12 дугаар сард дуусгасан байна.

1.4 Компани болон Засгийн газрын ОУИТБС-ын 2014 оны тайлан гаргах ажлыг зохион байгуулсан нь

Компанид тайлан гаргахад нь туслах зорилгоор 3, 5 дугаар сард 5 удаа сургалт, байгуулахад 200 орчим компанийн төлөөлөл оролцсон байна.

ОУИТБС-ын ажлын алба Ашигт малтмалын, Газрын тосны газруудтай хамтран ажиллаж, сургалт зохион байгуулж, сонин(2 сонин, нийт 10 удаа), цахим болон үүрэн телефоны сүлжээ(4 оператор, 3 удаа, нийт 2411 дугаарт) ашиглан зар сурталчилгаа хүргэсний үр дүнд цахимаар 992 компани (ашигт малтмалын компани 969, үүнээс 552 нь ашиглалтын тусгай зөвшөөрөл, 417 хайгуулын тусгай зөвшөөрөл бүхий, газрын тосны 12, уран 11 компани) цахимаар 2014 оны тайлангаа гаргасан байна.

2014 оны тайлангаа гаргаагүй 600 гаруй компанийн нэрсийг 4, 10 дугаар сард 2 сонинд, 2 удаа хэвлэн нийтэлсэн байна.

Засгийн газрын ОУИТБС-ын 2014 оны тайланг хугацаанд гаргах асуудлаар Сангийн яам, Татварын ерөнхий газартай хамтран ажиллаж, сургалт зохион байгуулж, зааварчилгаа өгсний дүнд Засгийн газрын харьяа 42 байгууллага 1573 (ашигт малтмалын компани 1553, үүнээс 920 нь ашиглалтын тусгай зөвшөөрөл, 633 хайгуулын тусгай зөвшөөрөл бүхий, газрын тосны 16, уран 15 компани)компаниас хүлээн авсан орлогоор ОУИТБС-ын тайлангаа цахимаар тус тус 4 дүгээр сарын 25-ны дотор гаргасан байна.

Засгийн газрын тайланд ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжүүдийн үнэмлэхүй олонхийг хамруулж чадсан байна.

1.5 ОУИТБС-ын тайлагнал

Тайланг гаргаж, нэгтгэл тайланд орж байгаа компаниудын тоо жил бүр нэмэгдэж, зөрүү жил бүр буурч байна.

Он	Тайлан гаргасан компани	Сангийн яамнаас гаргасан Засгийн газрын тайланд хамрагдсан компанийн тоот	Монгол Улсын нэгтгэл тайланд орсон компани	Тайлбарлагдаагүй зөрүү
2006	64	137	25	4 тэрбум төгрөг

2007	102	184	38	775 сая төгрөг
2008	115	184	46	425 сая төгрөг
2009	129	363	101	58 сая төгрөг
2010	274	477	150	360 мянган төгрөг
2011	301	518	200	75 сая төгрөг
2012	1529	1829	200	360 сая төгрөг
2013	1198	1617	250	36 сая төгрөг
2014	992	1573	236	581 сая төгрөг

1.6 Монгол Улсын ОУИТБС-ын 2013 оны нэгдсэн тайланг сурталчилах хүрээнд

2013 оны нэгдсэн тайлангийн дагуу 5 дэд хэсэг гарган ажиллуулж, эхний үр дүнг Үндэсний зөвлөл, Ажлын хэсэгт танилцуулсаны дагуу, нэгдүгээрт, гэрээнүүд цуглуулах, гэрээний ил тод байдлын цахим хуудас боловсруулах, хоёрдугаарт байгаль орчины нөхөн сэргээлтийн тусгай дансны хөрөнгийн талаар мэдээг гаргах, Үндэсний аудитын газарт танилцуулах, гүйцэтгэлийн аудит хийлгэх, гуравдугаарт Үндэсний статистикийн хороо, Сангийн ямаар ОУИТБС-ын тайлангийн маягтуудыг шинэчлэн батлуулах ажлуудыг зохион байгуулсан байна.

2013 оны тайлангийн мэдээллийг ашиглан 2015 онд бүх зохион байгуулсан сургалт, орон нутгийн хэлэлцүүлэг, өдөрлөг, бүсийн чуулганд зориулан сонгож авсан аймаг сумдаар, тухайлбал Төв, Дорноговь аймгийн болон Сэлэнгэ аймгийн Баянгол, Баянхонгор аймгийн Бөмбөгөр, Дорноговь аймгийн Айраг сумын тайлан хэвлүүлэн нийтэлж тараасан бол Баянхонгор, Сэлэнгэ аймгийн тайланг Германы ОУХАН, Монголиан майнинг журналтай хамтран мөн хэвлэн тараасан байна.

2013 оны тайлангийн мэдээллийг ашиглан, 230 компанийн хувь эзэмшигчдийн лавлагааг боловсруулж, Ажлын албаны цахим хуудас дээр байршуулсан нь хэрэглэгчдээс өндөр үнэлгээ авсан байна.

Ажлын албаны цахим хуудсыг хэрэглэгчдэд ойлгомжтой, хялбар болгож, 2013 оны нэгтгэл тайлангийн бүлэг бүрийг цэс болгон, шинэчлэсэн байна. Ажлын албаны цахим хуудаст 7513 хэрэглэгч хандсан байна.

1.7 Олон нийтийн мэдлэг ойлголтыг дээшлүүлэх, чадавхи бэхжүүлэх үйл ажиллагаа

1.7.1 Үндэсний түвшинд чадавхи бэхжүүлэх ажлын хүрээнд

Иргэний нийгмийн байгууллагын чадавхийг бэхжүүлэх зорилтын хүрээнд “Төлсөн авснаа нийтэл” эвслийн гишүүн 24 төрийн бус байгууллагад “Орон нутгийн иргэдэд зориулан мэдээлэл боловсруулах арга зүй” сэдэвт сургалт, Үндэсний аудитын газартай хамтран “Уул уурхайн нөхөн сэргээлтийн хөрөнгийн төвлөрүүлэлт, зарцуулалт, үр дүн” сэдэвт гүйцэтгэлийн аудитад зориулсан зайн болон танхимын хосолсон сургалтыг зохион байгуулж, сургалтанд Үндэсний аудитын газрын Гүйцэтгэлийн аудитын газрын 14 аудитор, шинжээчид, 11 аймаг, нийслэлийн аудитын газрын 47 албан хаагчид оролцсон байна.

Мөн ОУИТБС-ын Үндэсний чуулганыг 11 дүгээр сарын эхээр УУЯ, ННФ, БНЗХ- тэй хамтран 2 өдөр зохион байгуулж, төр засаг, олборлох үйлдвэрлэл эрхлэгчид, иргэний нийгмийн байгууллага, орон нутгийн төлөөлөгчид, эрдэмтэн судлаачид, олон улсын байгууллагууд зэрэг төлөөллийн 250 хүн оролцсон байна. Чуулганаас гаргасан гол үзэл санаа бол 2020 он хүртэл баримтлах стратегийн бодлогод боловсруулах, санал, чиглэл авах, 2016 оныг ОУИТБС- ын

дэд зөвлөлийг чадавхжуулах жил болгоё гэдэг дээр санаа нэгдсэн байна. ННФ, БНЗХ-гээс чуулганы зардлыг хамтран санхүүжүүлж, чуулганыг амжилттай зохион байгуулахад томоохон хувь оруулсан байна.

1.7.2 Орон нутгийн түвшинд чадавх бэхжүүлэх хүрээнд

“Монголиан Майнинг Журнал”, Германы ОУ-ын хамтын ажиллагааны нийгэмлэгтэй хамтран сэтгүүлчдийн “Орон нутгийн мэдээллийн сүлжээ” төслийг хэрэгжүүлж, 16 аймгийн 52 сэтгүүлчийг сургаж бэлтгэлээ.

6-р сард Сэлэнгэ аймгийн Мандал суманд Хойд бүсийн 2-р чуулган, 7-р сард Баянхонгор аймгийн Баянхонгор хотод Баруун бүсийн 2-р чуулган, 9-р сард Дорноговь аймгийн Сайншанд суманд Өмнөд бүсийн анхдугаар чуулганыг зохион байгуулж нутгийн удирдлага, компани, иргэд уул уурхайн салбарын ил тод байдлын асуудлаар санал бодлоо солилцож, хэлэлцүүлэг хийлээ. Бүсүүдийн чуулганд 12 аймаг, 24 сумын 382 төлөөлөгчид оролцсон байна.

Орон нутгийн иргэдэд мэдээлэл түгээх зорилт бүхий Төв аймгийн өдөрлөг, Сэлэнгэ аймгийн Баянгол, Баянхонгор аймгийн Бөмбөгөр, Дорноговь аймгийн Айраг сумдын өдөрлөгийг 5, 6, 9 сард зохион байгуулж нийт 280 хүн оролцсон байна.

Нийслэлийн ОУИТБС-ын дэд зөвлөлтэй хамтран 8 дүүргийн Засаг дарга, Засаг даргын орлогч нарт “Уул уурхайн үйлдвэрлэл болон олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг хэрэгжүүлэхэд орон нутгийн оролцоо, эрх үүрэг” сургалт зохион байгуулж нийслэлийн 2013 оны нэгтгэл тайлангийн үр дүнг танилцуулсан.

Орон нутгийн түвшинд нилээд хүчин чармайлт, цаг хөрөнгө гаргаж, ажиллаж тодорхой ахиц дэвшилд хүрч байна. Энэ чиглэлээр Иргэний нийгмийн байгууллагаас ихээхэн идэвх зүтгэл гаргаж байна. Цаашид орон нутагт хэрэгжүүлэх ажлыг санхүүжилтийг тогтвортой болгож, баталгаажуулах талаар бүх талууд чармайл хэрэгтэй байна.

1.8 Хэвлэл, мэдээлэл, олон нийтэд чиглэсэн ажлын хүрээнд:

ЗГХЭГ-тай хамтран 2015 оны 1-р сард Төрийн ордонд “Үндэсний зөвлөлийн 12-р хуралдааны тухай” хэвлэлийн бага хурал зохион байгуулж, МҮОНТ, UBS, Ийгл, Парламент, Стар Тв-ийн сувгаар мэдээ дамжуулж, 11,000 хүн үзсэн байна. Мөн 8 төрлийн мэдээллийн вэб хуудсуудад мэдээлэл байршуулсан байна.

МҮОНТ-ийн улс төр, нийгэм, эдийн засгийн сэтгүүлч Б.Оюунчимэгтэй хамтран ярилцлагын төрөлд рейтинг өндөртэй нэвтрүүлэг болох түүний “Цаг үе, үзэл бодол”-д Ажлын албаны зохицуулагч Ш. Цолмон зочноор оролцож ОУИТБС-ын хэрэгжилтийн талаар цаг үеийн мэдээлэл хийсэн. Мөн “Ил тод уул уурхай” сэдэвт 40 минутын нэвтрүүлгийг Булган аймгийн Бүрэгхангай сум, Төв аймгийн Заамар сумаас бэлтгэн МҮОНТ-ээр цацсан. Эдгээр нэвтрүүлгүүдийг 26,000 хүн үзсэн байна.

МҮОНТ-ийн ММ агентлагтай хамтран ажиллах гэрээ байгуулж, ОУИТБС-ын үйл явдлуудыг сурвалжлан, Цагийн хүрд мэдээллийн хөтөлбөрөөр дамжууллаа. 2015 онд нийт 7 удаа мэдээ цацаж, нийт 320,000 хүнд хүрсэн байна.

Блүүмбэрг ТВ-тэй хамтран ажиллах гэрээ байгуулж, ОУИТБС-ын Олон улсын удирдах хорооны дарга хатагтай Клэйр Шорт, МУУҮА-ийн ерөнхийлөгч Н.Алгаа болон ажлын албанаас оролцон ярилцлага өгсөн байна. Түүнчлэн Үндэсний чуулганыг бүрэн эхээр нь шууд сурвалжлан олон нийтэд хүргэв.

Үндэсний шуудан сонинтой хамтран ажиллаж 9 удаагийн нийтлэл, 5 удаа зар сурталчилгаа байршуулсан байна. Өдрийн сонинд тайлан гаргаагүй 746 аж ахуйн нэгжийн жагсаалтыг 3 удаа, тайлангаа хугацаандаа гаргах тухай зарыг 6 удаа тус тус нийтэлжээ.

“Монголиан Майнинг Журнал”- тай хамтран ажиллаж уг сэтгүүлийн 5, 6, 9 дүгээр сарын дугааруудад ОУИТБС-ын тухай нийтлэл, сурвалжлага нийтэлсэн байна.

Мөн www.ikon.mn сайттай хамтран 2013 оны нэгтгэл тайлангийн топ мэдээллүүдийн инфографикийг гарган байна.

Дисковер Монголиа чуулганд үзэсгэлэн гаргаж, дотоод, гадаадын хөрөнгө оруулагч нарт сурталчилгаа хийж, танилцуулсан байна.

Олон нийтэд зориулж ОУИТБС-ын брошур 2300 ширхэг, Стандарт 900 ширхэг, эрх зүйн эмхэтгэл 500 ширхэг, 2013 оны хураангуй тайлан 300 ширхэг, Төв, Дорноговь аймгийн болон Баянгол, Бөмбөгөр, Айраг сумын тайланг нийт 1600 ширхэг хэвлэсэн байна.

1.9 Дотоод харилцаа, холбоог сайжруулах хүрээнд:

Сургагч багш нарт зориулж мэдээллийг шуурхай солилцох, туршлага хуваалцах зорилго бүхий **facebook** бүлгийг нээж, үргэлжлүүлэн ажиллуулж байна.

Ажлын албаны www.eitimongolia.mn цахим хуудсыг шинэчлэж, 2015 онд 7513 зочин хандсан байна. Мөн facebook хуудас-320 лайк, twitter-169 дагагчтайгаар мэдээлэл түгээж байна. Flickr-ийн хуудас гаргаж, 1131 фото зураг оруулсан байна.

ОУИТБС-ын сар бүрийн цахим сонин бэлдэж, бүртгэлтэй 400 гаруй хэрэглэгчдэд цахим шуудангаар хүргүүлж байна. Тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжүүдийн захирлуудын 2411 гар утаст тайлан гаргах тухай зар, зааварчилгааг хүргүүлсэн байна.

1.10 Гадаад арга хэмжээний хүрээнд:

ОУИТБС-ын тэргүүн хатагтай К.Шорт тэргүүтэй төлөөлөгчдийн ажлын айлчлалыг зохион байгуулж, Монгол Улсын Ерөнхий сайд Ч.Сайханбилэг хүлээн авч уулзаж, ил тод байдлын ач холбогдлыг дэлгэрэнгүй ярилцаж, санал солилцсон байна. Хатагтай Клейр Шорт манай улсад 2012, 2015 онд айлчилснаараа Монгол Улс ОУИТБС-ыг тогтвортой хэрэгжүүлж байгааг газар дээр нь шалгах, үнэлэх, удирдах дээд албан тушаалтнууд, Үндэсний зөвлөл, Иргэний нийгмийн төлөөлөл, Компаниудын төлөөллүүдтэй бүгдтэй нь уулзан танилцаж, санал бодлыг нь сонсч мэдэхийн хамт цаашдын хандлагын талаар дүгнэлт хийсэн байна. ОУИТБС-ын стандартын шаардлагыг бүрэн хангахад ихээхэн хүчин чармайлт гаргахаар байна гэсэн ойлголттой буцсан байна.

Филипинд болсон Номхон далайн ОУИТБС-ын бүсийн зөвөлгөөн, Камбожид зохиогдсон ОУИТБС-ыг дэлгэрүүлэх семинар, Унгар, Турк улсуудад зохиогдсон сургалтад төлөөлөгчдөө илгээж, туршлагаа хуваалцсан байна. Филипинд болсон уулзалтаар Монгол Улс ОУИТБС-ыг олон жил хэрэгжүүлж байгаа ч, тусгай зөвшөөрлийн сонгон шалгаруултаар олгох тохиолдолд ямар журам, үнэлгээ хэрэглэдэг тодорхойгүй, ашигт малтмалын төслийг хэрэгжүүлэх эхлэхээс өмнө орон нутгийн иргэдэд нөхцөл байдлыг танилцуулдагаараа Филипин нилээд туршлагатай нь харагдсан байна.

ЕСБХБ-ны төслийн сүүлчийн ажил болох Перу улсруу туршлага судлах аялалыг зохион байгуулсан. Энэ судалгааны аялалаар ажилласан хүмүүсийн гол олж авсан мэдлэг Перу улсад уул уурхайтай холбогдсон маргааныг шийдвэрлэх Засгийн газрын байгууллагатай бөгөөд тэр нь улсынхаа Ерөнхийлөгчид тайлагнадаг байна.

Индонез улсын туршлага судлах, Бритиш Колумбийн их сургуулийн оюутнуудын хийсэн судалгааны танилцуулгыг зохион байгуулж, Германы Олон улсын хамтын ажиллагааны байгууллагаас “Их 7-ийн үр дүнд хурдан хүрэх түншлэл”- ийн 2 дугаар ажилд оролцсон байна.

ХОЁР. ОУИТБС- ЫН ШААРДЛАГУУДЫГ ХАНГАСАН БАЙДАЛ, ЯВЦ

ОУИТБС-ын шинэ стандартыг нэвтрүүлэх хүрээнд

2.1. 2013 оны нэгтгэл тайлан ОУ-ын стандартын шаардлагыг хангасан эсэх

Одоогийн хууль эрх зүйн орчин, ил байгаа мэдээллүүд, олон улсын зөвлөмжүүдийн дагуу салбарын үндсэн мэдээллүүдийг цуглуулах, боловсруулах ажлуудыг төв, орон нутгийн түвшинд зохион байгуулж, нэгдсэн сан бий болгож, цахим хуудсанд байршуулсан болно.

ОУ-ын НБДнГ, ГОУХАН-тэй хамтран шинэ стандартын дагуу баталгаажуулалтад бэлтгэх болон өөрийн үнэлгээний ажлыг зохион байгуулж, Ерөнхий сайдаар нэмэлт ажлын төлөвлөгөө гарган батлуулж, ажилласан бөгөөд туршилтын баталгаажуулалтыг зохион байгуулсан байна. Эдгээр даалгавруудын дагуу Сангийн яам, Байгаль орчин ногоон хөгжил, аялал жуулчлалын яам, Ашигт малтмалын газар, Газрын тосны газар, Эрдэнэс Монгол компаниудаас хариу ирүүлснийг 2013 оны тайлангийн нэмэлт байдлаар боловсруулан, урьдчилсан баталгаажуулалтад хүргүүлсэн болно.

Туршилтын баталгаажуулалтыг ОУНБДнГ-аас 11 дүгээр сарын эхээр зохион байгуулж, дараах дүгнэлтийг ирүүлсэн байна. ОУИТБС-ын стандарттай Монгол Улсын ОУИТБС-ын хэрэгжилт нийцэж байгаа эсэхийг шалгав. Урьдчилсан байдлаар 1.4, 3.4, 3.5, 3.6, 3.9, 3.10, 4.1а, 4.1с, 4.1е, 4.2а-с, 5 болон 7.2 –хангаагүй байна.Эдгээрийн зарим нь “багахан ахицтай ч хангаагүй” гэсэн үнэлгээтэй байна.

Голлон Засгийн газар, компаниудаас гаргасан тоо мэдээллүүд баталгаатай эсэх нь тодорхойгүй, төрийн өмчийн компаниудаас нийгмийн чиглэлийн хөрөнгө оруулалт, төрийн өмчийн компаниуд Засгийн газрын хоорондын санхүүгийн журам, биет орлогуудыг ил тод болгох нь дутагдалтай байна.

Үндсэн дүгнэлтүүд:

Монгол Улс ОУИТБС-ыг хэрэгжүүлэгч анхны улсуудын нэг. ОУИТБС-ын тайландаа хамгийн олон тооны компаниудын тайланг хамруулж чадаж байгаа орон. Мөн байгаль орчны урьдчилгаа, орон нутгаар тайлан гаргуулж, дэд зөвлөлийг байгуулан цахимаар тайлагнаж чадаж байгаа юм.

Бас нэг онцлог Стандартад заагаагүй асуудлыг ОУИТБС-ын хүрээнд хэрэгжүүлж байгаа нь орон нутгийн түвшинд чухал ач холбогдолтой, шинэлэг зүйл болж байна. Стандарт гарахаас өмнө компанийн нийгмийн чиглэлийн төлбөр, байгаль орчины нөхөн сэргээлтийн зардлыг ил болгож байв.

Олон талт оролцогчдын хэсэг (ОТОХ) нь харилцан итгэлтэй болж байгаа ч, хяналт үнэлгээнд илүү анхаарч, өөрсдөө хэрэгжүүлэхэд оролцохдоо сул байна. Энэ үүргийг Ажлын алба гүйцэтгэж байна. Үндэсний зөвлөл өндөр түвшиний ерөнхий удирдлагыг хангаж байна. Иймд оролцогч талуудын бүтцийг эргэн харж, хэрэгжилтэд ОТОХ-ийн оролцоог сайжруулж, Ажлын албаны удирдан чиглүүлэх ачааллыг бууруулах хэрэгтэй байна.

ОУИТБС- д Монгол Улс нилээд хэцүү орон гэж хэлэхээр байдаг нь татвар байнга өөрчилдөг, 1500 ААН оролцогоос 400 нь тогтмол үйл ажиллагаа явуулдаг, харин 2012 оноос хойш салбар нь зогсолтод орсон. Түүнээс 200 гаруйг нь тулган баталгаажуулалтад хамруулдагаас салбарын бусад үндсэн мэдээллүүдийн ил тод байдлыг стандартын дагуу хангаж чадахгүйд хүрээд байна.

Монголын ОТОХ нь стандартад заасан үндсэн мэдээллүүдийг яг стандартад зааснаар гүнзгийрүүлж ил тод болгоогүй байна. Хэрэв төрийн өмчийн компаниудын ил тод байдлыг стандартын дагуу ил тод болгож чадвал олон нийтэд мэдээлэл ил болохоос гадна хөрөнгө оруулагч, шийдвэр гаргагч нарт ч хэрэгтэй зүйл болох юм. Төрийн өмчийн компаниудад зээл, түүний өрийн асуудал улс төрийн хувьд эмзэг ч, АМГ-аас гаргаж байгаа үйлдвэрлэлийн мэдээнээс өөр нийтэд нээлттэй мэдээлэл байхгүй байна.

Монгол Улс нэгэнт уул уурхайгаас гүнзгий хамааралтай тул салбарын удирдлагын талаар өргөн хэлэлцүүлэг хийх хэрэгтэй байна. ОУИТБС нь голчлон орон нутгийн түвшинд хэлэлцүүлэг өрнүүлж чадаж байгаа ч, түүнтэй адил. Улаанбаатарт, үндэсний хэлэлцүүлэг зохион байгуулахгүй байна.

Хэдийгээр Үндэсний зөвлөлд дээд шатны удирдлага ордог хэдий ч хэлэлцүүлэг өрнүүлэхгүй байна.

Зөвлөмжүүд:

ОУИТБС-ын бүтэц, бүрэлдэхүүнээ эргэн харж өөрчлөх, илүү хурдан шуурхай, тогтмол хуралдах, өөрөөр хэлбэл, илүү хамтын шийдвэр гаргах, ямар ч хэсэг хуралдсан, ямар хурал болсон бүх мэдээллээ сайтар тэмдэглэж, хэвлэн нийтэлж байх. 3 тал асуудлаа 3 талаасаа харж, хэлэлцэж яаж шийдэхээ илэн далангүй хэлэлцэх ёстой. Ингэснээр зорилтоо тодорхой болгох, ойлгож авахад чухал алхам болно.

Ил тод байдлыг Засгийн газрын системд оруулахыг илүү анхаарч ажиллах хэрэгтэй байна. Цахим тайлагналын 2 дугаар шатны ажил энэ талаар илүү туслах ёстой. Тиймээс стандартын

дагуу салбарын ямар үндсэн мэдээлэл ил болсон, ямарыг нь 2016 онд ил болгох гэдгийг тодорхойлно шүү. Нээлттэй болгох хэлбэр загвараа сайтар тооцох ёстой.

2015 оны тайланг гаргахад Засгийн газар, ААН-үүдийн тайлан, мэдээллийг баталгаажуулах талаар ажил хэрэгч байх хэрэгтэй байна. Үндэсний аудитын газар, Хараат бус нэгтгэгч хянагч, салбарын мэргэжлийн зөвлөлтэй хамтран ажиллах хэрэгтэй байна. Ирэх жил сонгон шалгаруулалтаа эртхэн дуусгаж, ажлаа эрт эхлэх хэрэгтэй байна.

Жил бүрийн тайлангаар гарч буй зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх талаар ажил хэрэгч, идэвхтэй ажиллах хэрэгтэй байна. Оролцогч талуудын зөвлөгөөнийг албажуулах, Үндэсний зөвлөл, Ажлын хэсгийн гишүүнээс давсан гэхгүйгээр үндэсний хэмжээний хэлэлцүүлэгт саналаа оруулдаг болох.

Орчин үеийн мэдээллийн технологийг ашиглан иргэдийг хэлэлцүүлэгт оруулах боломжийг нээх. Ингэснээр хэлэлцүүлгийн хурдан шуурхай түгээхэд илүү тохиромжтой болно.

Туршилтын баталгаажуулалтын үр дүнг Ажлын хэсгээр 2015 оны 12 дугаар сард хэлэлцэж, 2016 оны Ажлын төлөвлөгөөнд нэмэлт ажлууд оруулсан байна.

2.2. 2014 оны нэгтгэл тайлан ОУ-ын стандартын шаардлагыг хангасан эсэх

ОУИТБС-ын стандартын шаардлагуудад аль болох нийцүүлэхээр Кей Пи Эм Жи компанийн баг ажиллаж, Ажлын хэсэг, албанаас 7 дугаар сараас 12 дугаар сар хүртэл 5 сар хамтран ажилласан. Үүний үр дүнд тэдний боловсруулсан Монгол Улсын ОУИТБС-ын 9 дүгээр буюу 2014 оны нэгтгэлийн тайланд стандартын шаардлага бүрээр мэдээлэл гаргасан бөгөөд Ажлын хэсгээс санал өгч, хүлээн зөвшөөрсний үндсэн дээр Үндэсний зөвлөлд танилцуулж, батлуулсан билээ.

Тайлангаар гарсан зөвлөмжүүдийг хүлээн авахуйц, хэрэгжүүлж болохуйц гэж үзэн 2016 оны ажлын төлөвлөгөөнд тусган холбогдох шийдвэрүүдийг Үндэсний зөвлөлөөс гаргасан

ГУРАВ. БАТАЛГААЖУУЛАЛТЫН ЗӨВЛӨМЖИЙН ДАГУУ ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ, АЖЛЫН ХЭСГЭЭС ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТОЙМ

3.1. Үндэсний зөвлөлийн хуралдаан

Монголын ОУИТБС-ын Үндэсний зөвлөл 2015 онд 3 удаа хуралдсан байна. 2015 оны 1, 6 дугаар сарын хуралдаанаас 20 орчим шийдвэрүүд гарснаас 30 хувийн биелэлттэй байна.

Биелэгдэхгүй байгаа гол ажил бол Эрдэс баялагийн салбарын ил тод байдлын хуулийн төслийг батлах, батлуулсанаар бүтэц зохион байгуулалт, санхүүжилтийн өөрчлөлт журам батлах, мөн ОУИТБС-ын хэрэгжилтийг УИХ, түүний байнгын хороодод танилцуулах, Засгийн газрын тайланг аудитаар баталгаажуулах, зарим аймгуудад ОУИТБС-ын мэдээллийн төв байгуулах зэрэг ажлууд орсон байна.

3.2. Ажлын хэсгийн хуралдаанууд

ОУИТБС-ыг хэрэгжүүлэх үүрэг бүхий Ажлын хэсгийн ээлжит хуралдаанууд 2015 онд 3 удаа зохиогдож, ирц 70 орчим хувьтай байсан.

Ажлын хэсгийн хуралдаанаас 10 гаруй шийдвэрүүдийг гаргаж, цаг үетэй холбогдсон шинжтэй шийдвэрүүд байсан тул харьцангуй биеллээ олж ирж ирсэн байна. 2015 онд нилээд ажлыг Ажлын дэд хэсгүүдийг ажиллуулж, шийдвэрлэхийг оролдсон тул Ажлын хэсгийн ачаалал бага байсан.

3.3.ОИТБС-ын тухай хуулийн төслийг Улсын Хурал дээр хэлэлцсэн нь

Эрдэс баялагийн салбарын ил тод байдлын тухай хууль буюу Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийн төслийг Монгол Улсын Их хурал 2 дугаар сард хэлэлцэж, уг төслийг хэлэлцэхээр шийдэж, Эдийн засгийн байнгын хорооны ажлын хэсгийг байгуулж, анхны хэлэлцүүлэгт бэлтгэхийг даалгасан. Ажлын хэсэг 2 удаа хуралдаж, тодруулга авсан хэдий ч, ажлаа үргэлжлүүлэх эсэх нь тодорхойгүй байна.

3.4.ОУИТБС-ын санхүүгийн тогтвортой эх үүсвэрийн тухай

Монгол Улсын Засгийн газраас ОУИТБС-ын хэрэгжүүлэх ажлын санхүүгийн эх үүсвэрийг баталгаажуулах үүднээс нэгтгэл тайлангийн санхүүжилтийг 2010 оноос эхлэн улсын төсвөөс санхүүжүүлж байгаа бөгөөд 2012 онд 201,1 сая төгрөг, 2013 онд 183 сая төгрөг, 2014 онд 220,1 сая төгрөг, 2015 онд 169 сая төгрөг зарцуулсан байна. Ирэх 2016 онд 255 сая төгрөг зарцуулах төлөвлөгөөтэй болно. Эдгээр төсвийн хөрөнгийг ихэнхи хэсгийг жил бүрийн нэгтгэл тайланг боловсруулахад зарцуулж байна.

Ажлын албаны санхүүжилт Дэлхийн банкны итгэлийн сангийн санхүүжилтээр хэрэгжиж байна. Санхүүжилтийн хувьд 2015 оны 12 дугаар сард дуусч, 480 орчим сая төгрөгийн төслийг хэрэгжүүлнэ. 2016 оны санхүүжилтийг 153,5 сая төгрөгөөр тооцон, ажлын төлөвлөгөө, төсвийн төслөө боловсруулаад байна.

3.5. Цахим тайлагналын 2 дугаар шатны ажлын тухай

Европын сэргээн босголт хөгжлийн банкны санхүүжилтээр(300,000 евро) цахим тайлагналын 2 дугаар шатны ажлыг эхлүүлээд байна. Энэ хүрээнд Татварын ерөнхий газар, Ашигт малтмалын газрын кадастрын сүлжээтэй холбоотой байж, шинэ мэдээлэл тогтмол солилцох, график дизайны шинэ боломжийг ашигладаг болно. Мөн гаргасан тайлангуудыг хоорондын мэдээллийг харьцуулах, боловсруулалтыг сайжруулах юм. 2016 оны 9 дүгээр сард уг ажил дуусах төлөвлөгөөтэй байна.

ДӨРӨВ. АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН БАЙДАЛ

4.1. 2015 онд нийт 50 үйл ажиллагаа хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд 47 үйл ажиллагааг хэрэгжүүлж, биелэлт 90 хувьтай байна.

4.2. Хэрэгжүүлж чадаагүй гол ажил нь ОУИТБ-ын хуулийн төслийг батлуулахтай холбогдон хэрэгжүүлэх ажил, хандив хөрөнгө оруулалтын тухай хэлэлцүүлэг, ОУИТБС-ын стандарт хууль эрх зүйн орчны семинар зэрэг ажлууд хийгдээгүй болно.

ТАВ. ЦААШИД ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ЧИГЛЭЛ, ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ОРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛЭХ ТУХАЙ

ОУИТБС-ын үйл явцын талаархи Ажлын хэсгийн дүгнэлт

5.1. Монгол Улсын ОУИТБС-ын 9 удаагийн нэгдсэн тайланг гаргаж, тайлангаас тайланд хамрагдаж байгаа компанийн тоо нэмэгдэж, аудитын нэгтгэлээр гарч байгаа зөрүү багасч байна.

- 5.2. ОУИТБС-ыг хэрэгжүүлэхэд оролцогч талууд Засгийн газрын оролцоо дунд, компанийн оролцоо идэвхгүй байгааг цаашид анхаарах, харин иргэний нийгмийн байгууллагуудын оролцоо, санаачлага сайн байна.
- 5.3. Цаашид нэгтгэл тайлангийн ашиглалтыг сайжруулах, ЗГ-ын 222-р тогтоолын дагуу УИХ-ын Эдийн засгийн байнгын хороонд танилцуулах, урьд жилүүдийн нэгтгэл тайлан хооронд харьцуулан дүгнэлт гаргаж, бодлого боловсруулахад ашиглалтыг сайжруулах ажлыг зохион байгуулах
- 5.4. Монголын ОУИТБС-ын Үндэсний чуулганаас гарсан санал, зөвлөмжийн дагуу 2020 он хүртэл баримтлах стратеги төлөвлөгөө боловсруулж, хүрэх зорилгоо тодорхой болгох
- 5.5. Монгол Улсад ОУИТБС тогтвортой хэрэгжиж байгаа ч хөрөнгө санхүүгийн хязгаарлагдмал байдал, хууль эрх зүйн тодорхойгүй байдлаас улбаалан томоохон шинэчлэл, өөрчлөлтийг хийх бололцоо дутмаг байгааг хүлээн зөвшөөрч байна.
- 5.6. МУ-ын ОУИТБС-ыг хэрэгжүүлэх хүрээнд төлөвлөгдсөн зарим ажил, үйл ажиллагааг олон талт ажлын хэсгийн бүрэлдэхүүнд оролцож буй уул уурхайн салбарын мэргэжлийн холбоод, иргэний нийгмийн байгууллагуудад гэрээлэн гүйцэтгүүлэх ажлыг хийх замаар ажлын албаны ачааллыг багасгах

ЗУРГАА. МОНГОЛ УЛСАД 2015 ОНД ОУИТБС-ЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ҮҮСЭН БЭРХШЭЭЛ, ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ, АВСАН СУРГАМЖ

Монгол Улсад ОУИТБС-ыг тогтвортой, харьцангуй амжилттай хэрэгжүүлж байна. Санхүүгийн эх үүсвэр үе үе доголдох хандлагатай явж ирсэн байна.

Засгийн газрын байгууллагуудын оролцоо сайн байгаа ч, холбогдох байгууллагуудын дээд шатны удирдлагын оролцоо хангалтгүй байна.

Компаниудын оролцоо харилцан адилгүй байна. Томоохон компаниудын удирдлагын оролцоо идэвхгүй байна. Хөдөө орон нутагт зохиогдож буй арга хэмжээнд компаниудын төлөөлөл төдийлэн сайжрахгүй байна.

Иймд Засгийн газар, компаниудын төлөөллийн оролцоог сайжруулах талаар талууд хамтран ажиллах хэрэгтэй байна.

ДОЛОО. БАТАЛСАН ОГНОО 2015 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДӨР